



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 18 өдөр

Дугаар 9/56

Амардалай

Мал угаалгын ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.1, 21.4 дэх заалт, Аймгийн Засаг даргын 2022 оны А/326 тоот захирамжийн хавсралт "Малын шимэгчтэх өвчнөөс эмчлэх сэргийлэх мал угаалгын ажлыг хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих ажлын удирдамж"-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал угаалгын ажлыг 2022 оны 07 дугаар сарын 25-наас 9 дүгээр сарын 25-ны өдөр хүртэл хугацаанд зохион байгуулсугай.

2. Мал угаалгын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Наранцэцэг (МЭТ-ийн дарга)

Гишүүд: Б.Довуучий (1-р багийн Засаг дарга)

Г.Сосорбурам (2-р багийн Засаг дарга)

Б.Баатарсүрэн (3-р багийн Засаг дарга)

М.Даваацэрэн (Малын эмч)

М.Ганьхүү (Малын эмч)

Э.Дэлгэрмаа (Малын эмч)

3. Мал угаалгын зар товыг малчдад хүргэх, мал угаалгыг идэвхжүүлэх, оролцоог хангах, малын эмч нарыг дэмжин ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Малын шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал угаалгын төлөвлөгөөний дагуу бог малыг бүрэн хамруулах, дүрэм, журам, холбогдох стандартын дагуу чанартай хийж гүйцэтгэхийг Мал эмнэлгийн нэгжийн эмч (М.Даваацэрэн), (Э.Дэлгэрмаа), (М.Ганьхүү) нарт, мал угаалгын явцад хяналт тавьж, захирамжийн хэрэгжилтийг хангуулан ажиллахыг МЭТ-ийн дарга (Д.Наранцэцэг)-т тус тус үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГА

М.БАЯРСҮХ

4880037002